

## АШГИЙН ТӨЛӨӨ БУС ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГАД ӨГӨХ ТББ-ЫН САЛБАРЫН САНАЛ

Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн  
ТББ-уудын цуврал хэлэлцүүлэг  
2019.06.06-21, Улаанбаатар хот

Ардчиллын боловсрол төв (ДЕМО)-өөс 2019 оны 6 дугаар сарын 6-21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо ТББ-уудын анхаарлын төвд байсан “Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хууль” (АТБХЭтХ)-ийн төслийн хэлэлцүүлгийг ТББ-ын өргөн төлөөлөлд дөрвөн удаагийн цувралаар зохион байгуулсан бөгөөд энэхүү хэлэлцүүлэгт эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, ахмад, сайн дурынхан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, боловсрол, эрүүл мэнд, уул уурхай, байгаль орчин, экологи, мэргэжлийн холбоод, хүний эрх, ил тод байдал, авлигатай тэмцэх зэрэг чиглэлээр ажилладаг 200 гаруй ТББ-ын төлөөлөл оролцсон.

Дээрх цуврал хэлэлцүүлэг нь ХЗДХЯ-ны Ажлын хэсгийн боловсруулсан 2019 оны 5-р сарын 10-ны өдрийн Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын хувилбар дээр явагдсан бөгөөд Хараат бус судалгааны хүрээлэнгийн АТБХЭтХ-ийн төсөлд хийсэн дүн шинжилгээ, ТББ-ын экспертүүдийн Консорциум, ДеФакто хүрээлэн болон хэлэлцүүлэгт орсон ТББ-уудын хуулийн төсөлд өгсөн саналуудыг эмхэтгэн нэгтгэн толилуулж байна.

Тулгамдаж буй асуудал	Санал	Үндэслэл/Тайлбар
I. Хуулийн үйлчлэх хүрээг дэлгэрүүлэн тодорхойлох шаардлагатай	3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ - “3.1 ... зэрэг бусад ашгийн төлөө бус хуулийн этгээдэд зориулан тусгай хууль баталсан бол тэр хууль нь АТБХЭ-ийн тухай энэ ерөнхий хуульд нийцсэн байх болно” гэж уг заалтыг засаж найруулах.	<ul style="list-style-type: none"> <li>- Нэр бүхий ашгийн төлөө бус байгууллагууд нь өөрийн тусгай хуультай байж болох боловч, тэр нь АТБХЭ-ийн ерөнхий хуульдаа нийцэж байх нь ашгийн төлөө бус этгээдийн эрх зүйн зарчим юм.</li> <li>- Зарим ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зохицуулсан тусгай хууль нь АТБХЭ-ийн энэ ерөнхий хуулийг давж үйлчлэх орон зайг үүсгэж болзошгүй.</li> </ul>

<p>II. Ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хориглох зүйлээр эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг хязгаарлах эрсдэл</p>	<p>6 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдэд хориглох зүйл</p> <ul style="list-style-type: none"> <li>- 6.2.1-ийн заалтыг хасах. Эсхүл яг юуг хориглож байгааг маш тодорхой бичиж оруулах.</li> <li>- “6.2.2. ... шашин номлох, ухуулан дэлгэрүүлэх үйл ажиллагаа явуулах;” гэдэг нь хэт ерөнхий томъёологдсон тул мушгин гуйвуулж болох эрсдэлтэй. Тодорхой томъёолох эсвэл хасах.</li> <li>- “6.2.3.үндсэн зорилго, үйл ажиллагаагаа өөрчилж, ашгийн төлөө ажиллах, аливаа хэлбэрээр ашиг хуваарилах;” үндсэн зорилго, үйл ажиллагаагаа өөрчилж болохгүй гэх давхар утга агуулах магадлалтай тул энэ хэсгийг дараах “ашгийн төлөө ажиллах, ...” хэсэгтэй уялдуулан найруулах.</li> <li>- Хуулинд орсон хориглох зүйлийг холбогдох хуулиудаар зохицуулж, энэ хуулиас хасах эсвэл багасгах.</li> <li>- 6.2.5 болон 15.5 заалтууд давхцаж буй мэт харагдаж байгаа тул томъёоллыг эргэн харах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Аливаа байгууллагын хөгжлийн явцад эрхэм зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл үүргийг өргөтгөх, өөрчлөх, шинэчлэх, нэгдэх тохиолдол байх тул “үндсэн зорилго, үйл ажиллагаагаа өөрчилж болохгүй” гэх утга агуулвал АТБХЭ-ийн өсөн хөгжих боломжийг хязгаарлах эрсдэлтэй юм.</li> <li>- ТББ-ын өмнөх хуулийн төслүүдтэй харьцуулахад энэ хуульд хориглох зүйлийг нилээд оруулсан байна. Хязгаарлах үйл ажиллагаатай холбоотой хэтэрхий ерөнхий, хоёрдмол утгатай зүйл заалтууд болон зохицуулалтыг нарийвчлан боловсруулах замаар ардчиллын суурь зарчим, иргэний нийгмийн чөлөөт байдлыг баталгаажуулах шаардлагатай байна.</li> <li>- 6 дугаар зүйлээс гадна хориглож хумисан 17, 18 дугаар зүйлүүд байна, мөн зарим зүйл дотор бас орсон байна.</li> </ul>
<p>III. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн нэр, бүртгэлийн зөрчил, бүртгэлийн байгууллагын хүнд суртлын нөхцөл бүрдсэн байна</p>	<ul style="list-style-type: none"> <li>- 8.4. “... ашгийн төлөө бус хуулийн этгээд нь МОНГОЛЫН, ҮНДЭСНИЙ, НЭГДСЭН гэсэн үг оролцсон нэртэй байж болохгүй” гэсэн хэсгийг хасах</li> <li>- АТБХЭ-ийн үүсгэн байгуулагч иргэд нэрээ өөрсдөө сонгох эрх чөлөөг хамгаалах баталгааг энэ хууль болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд тусгах.</li> <li>- Төрийн бус байгууллагыг байгуулахад тавигдах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ зохицуулалт нь иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, өөрсдийн итгэл үнэмшил, бахархалын дор эвлэлдэн нэгдэх эрх, үүсгэн байгуулах байгууллагын эрхэм зорилго, үйл ажиллагааны онцлогтой холбоотой нэрийг чөлөөтэй сонгох, бүртгүүлэх боломжийг хязгаарлаж байна.</li> </ul>

	<p>хязгаарлалт, шаардлагын босгыг бууруулах, үүсгэн байгуулахад хялбар байдлыг хангах.</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлоороо эвлэлдэн нэгдсэн иргэд үүсгэн байгуулах хуулийн этгээдийн нэр сонгох эрх нь нээлтэй байх явдал нь хүний үндсэн эрх чөлөө, ардчилал, эрх зүйт ёсны шаардлага бөгөөд үүнийг хязгаарлах хууль зүйн үндэс байхгүй.</li> </ul>
	<ul style="list-style-type: none"> <li>- АТБХЭ-ийн бүртгэлийг хариуцах төрийн эрх бүхий байгууллага нь мэдлэг чадвар бүхий мэргэжлийн хүний нөөцөөр хангагдсан, өөрийн үүргийг биелүүлэх бүрэн боломжтой байх ёстойг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль болон холбогдох хуулиудад тусгах.</li> <li>- АТБХЭ-ийг бүртгэл бүх этгээдүүдийн хувьд /хувь хүн, хуулийн этгээд/ хөнгөн, шуурхай, хүнд сурталгүй байх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Төр нь бүрхэг, оновчгүй, хэт ерөнхий утга агуулгатай хуулийн зохицуулалтаар эвлэлдэн нэгдэх эрх чөлөөг боймлох явдлаас зайлсхийх үүрэгтэй. (Иргэний нийгмийг хамгаалах Олон улсын зарчмууд)</li> <li>- Хавсралт №1-ийг харна уу.</li> </ul>
	<p>17 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах</p> <ul style="list-style-type: none"> <li>- “17.2.Ашгийн төлөө бус хуулийн этгээд зохион байгуулалтын хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөн байгуулагдахыг хориглоно.” томъёоллыг ойлгомжтой болгох.</li> </ul> <p>18 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийг татан буулгах</p> <ul style="list-style-type: none"> <li>- “18.1.3. энэ хуулийн 6.2.1, 6.2.2, 6.2.3-т заасныг зөрчсөн нь тогтоогдсон;” энэ заалтаас 6.2.3-ыг залруулан томъёолох эсвэл хасах.</li> <li>- “18.1.6.ашгийн төлөө бус хуулийн этгээд нь үндсэн зорилгоо өөрчилсөн.” энэ заалтыг хасах.</li> <li>- “18.2.Шүүх энэ хуулийн 18.1.2, 18.1.3, 18.1.4-т заасан үндэслэлээр ашгийн төлөө бус хуулийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- 17.2-ын томъёоллыг анхаарах хэрэгтэй. Зохион байгуулалтын хэлбэр гэдэг нь удирдлага зохион байгуулалт мөн эсэх, үндсэн зорилго гэдэг нь нийтийн сайн сайхны төлөө ашгийн бус үйл ажиллагаа явуулах зорилгыг хэлж байгаа эсэх, ингэснээр “ашгийн төлөө этгээд” болж өөрчлөхийг хориглож байгаа бол энэхүү томъёолыг тодорхой болгох.</li> <li>- АТБХЭ-ийг бүртгэлийн, хууль хяналтын байгууллага эсвэл шүүхээс зөвхөн ноцтой зөрчил гаргасан, тэр нь нотлогдсон</li> </ul>

	<p>этгээдийг татан буулгана.” энэ заалтын 18.1.3-ыг засаж томъёолоогүй тохиолдолд хасах.</p> <ul style="list-style-type: none"> <li>- “18.3. Энэ хуулийн 18.1.5, 18.1.6-д заасан үндэслэлээр ... байгууллага гаргана.” энэ заалтаас 18.1.6-ааг хасах.</li> <li>- “18.4. Шүүхэд ...18.1.3-т заасан үндэслэлээр сонирхогч этгээд гаргана.” энэ заалтын 18.1.3-ыг засаж томъёолоогүй тохиолдолд хасах.</li> <li>- “18.5. Шүүх “болон” гэхийн оронд “буюу” гэх.</li> <li>- “18.6. Энэ хуулийн 18.1.1, 18.1.2, 18.1.3, 18.1.4-т заасан үндэслэлээр ... татварын албанд мэдэгдэнэ.” энэ заалтын 18.1.3-ыг засаж томъёолоогүй тохиолдолд хасах.</li> </ul>	<p>тохиолдолд албадан татан буулгах, үндсэн эрхүүдийг зөрчөөгүйг батлах үүднээс бүх албадан татан буулгах ажиллагааг шүүхийн хяналт дор явуулах нь чухал.</p>
<p>IV. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн үйл ажиллагааг зогсоох, цуцлах болон татан буулгах зохицуулалт тодорхой бус, эрсдэл бүхий байна</p>	<p>ТББ байгууллага хуулийн нэр томъёог эрх зүйн байрмт бичгүүдэд хадгалах. Ашгийн төлөө бус хуулийн этгээд гэх мэт бусад хуулиас урган гарч буй нэр томъёо ангиллыг уялдуулах шаардлагатай.</p> <p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томъёо</p> <ul style="list-style-type: none"> <li>- “бүртгэгдсэн холбоо”, “эдийн засгийн холбоо”, “нийтийн сан”, “хувийн сан”-ийн томъёоллыг нарийвчлан тодорхойлж оруулах</li> <li>- “6.3.-т орсон тайлбар”-ыг 4-р зүйлд оруулах эсвэл хасах</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- ТББ-ууд нь ажиллаж байгаа салбар, орон нутаг, цар хүрээ, байгууллагын хэмжээ, харилцагч зэргээс шалтгаалж ихээхэн ялгаатай онцлогуудтай байна. Ялангуяа орон нутагт үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудад хуулийн хэрэгжилт нь тэдний үйл ажиллагаанд нөлөөлөх эрсдэл байна. Төрийн бус байгууллагын төрөл, хэлбэрийг төрөлжсөн байдлыг хангах шаардлагатай.</li> <li>- Энэ хуулийн төслөөр одоо үйл ажиллагаа явуулж байгаа нийгэмд үйлчилдэг, гишүүнчлэлгүй ТББ-ууд “бүртгэгдсэн холбоо”, “нийтийн сан” гэсэн хоёр хувилбараас сонгох шаардлага гарч байна. Бүртгэгдсэн холбоо болно гэж үзвэл,</li> </ul>

		<p>             гишүүнчлэлгүй байгууллагууд              гишүүн элсүүлэх, үүсгэн              байгуулагчдаа гишүүд болгох, эсхүл              удирдах зөвлөлийн гишүүдийг              гишүүд гэж үзэх эсэхийг ойлгомжтой              болгох хэрэгтэй байна. Түүнчлэн, бүх              гишүүдийн хуралд удирдах              зөвлөлийн гишүүдийг суулгах эсэх,              тэднээс хэдийг нь холбооны УЗ-ийн              гишүүн болгох зэрэг зохицуулалтыг              тодруулах шаардлагатай байна.         </p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийтийн сан болно гэвэл олон асуудал гарч байна. Үүнд: Сан нь бусдын үйл ажиллагааг дэмжихийн тулд сан бүрдүүлдэг ба өөрсдөө үйл ажиллагаа явуулдаггүй гэсэн сангийн тухай ойлголт. Өөрөөр хэлбэл, сангийн үйл ажиллагаа нь хөрөнгө босгож бусдын үйл ажиллагааг дэмжих. Гэтэл төрийн бус байгууллага нь зорилгынхоо төлөө хэрэгжүүлэх үйл ажиллагаагаа санхүүжүүлэх хөрөнгө босгодог ба тэр хөрөнгөө өөрсдийн зорилгоо хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулдаг. Гэхдээ одоогийн ТББ-ыг Бүртгэгдсэн холбоо болгоход ч хэцүү, Нийтийн сан болгоход ч хэцүү байгааг анхаарч яг энэ асуудал дээр нэлээд нухацтай ярилцаж гарц хайх хэрэгтэй байна.</li> <li>- ТББ гэсэн ойлголт хэрэглэгдээд 20</li> </ul>
--	--	--

		<p>гаруй жил, иргэний нийгэм гэсэн ойлголт 30 гаруй жил болж байна. Энэ хэрээр Монголд тодорхой хэмжээнд иргэний нийгэм хийгээд төрийн бус байгууллагын соёл, үнэт зүйл, үзэл хандлага төлөвшиж, энэ хэрээр нийгэмд тодорхой нөлөө үзүүлж байна. АТБХЭтХ-д эдгээр ойлголтуудыг огт хэрэглэхгүй байгаа нь эдгээр ардчиллын институц, тэдгээрийг тээж буй үнэт зүйл, гүйцэтгэж буй үүргийг нийгэмд бүрхэгдүүлэх эрсдэлтэй. Иргэний хуулинд хуулийн этгээдийн ангиллыг ашгийн төлөө болон өшгийн төлөө бус гэж ангилсан нь ТББ-ын тухай хууль, түүний нэр томъёо, үзэл байримтлалыг өөрчлөх үндэслэл болохгүй.</p>
<p>7. Хуулийн нэр томъёо тодорхой бус, ойлгомжгүй</p>	<p>14 дугаар зүйл. Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн санхүүжилт</p> <ul style="list-style-type: none"> <li>- “14.1.5. Гадаад улс, олон улсын байгууллагын төсөл хөтөлбөр, хандив, тусламж” гэсэн шинэ заалт оруулах.</li> <li>- “14.2. Гадаад улсын тусгай албад, түүний халхавч байгууллага болон үндэсний эв нэгдэлийг бусниулах, мөнгө угаах, террорист болон экстремист үйл ажиллагаа явуулдаг, санхүүжүүлдэг байгууллага, хувь хүнээс, эсхүл хандивлагч нь тодорхойгүй санхүүжилт авахыг хориглоно.” Энэ заалтыг хасах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Энэ заалтад дурьдсан байгууллагын үйл ажиллагаа, хориглолт, хяналт нь бусад хуулиар зохицуулагддаг.</li> <li>- АТБХЭ-ийн санхүүжилтийн эх үүсвэрийг одоо байгаагаас хумих бус, харин нэмэгдүүлж хуульчлах хэрэгтэй.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"> <li>- “14.3. Энэ хуулийн 14.2-т заасан хувь хүн, байгууллагын талаарх мэдээллийг цагдаагийн болон тагнуулын байгууллага хамтран гаргаж нээлттэй мэдээлнэ.” энэ заалтыг мөн хасах. Холбогдох хуулиар зохицуулагдах тул.</li> </ul> <p>Тухайн хүрээнд холбогдох санал</p> <ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн үзэл баримтлалд АТБХЭ-ийг нийгмийн даатгалын хураамж, хандивыг татвараас чөлөөлөх зэргээр дэмжлэг үзүүлэх тухай агуулга хуулийн төсөлд байхгүйг хуулийн төсөлд бүрэн тусгах. АТБХЭ-ийг Нийгмийн даатгалын дарамтаас чөлөөлөх, АТБХЭ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаагаас бусад ажилтныг нийгмийн даатгалын сайн дурын хэлбэрт хамруулах</li> <li>- Төрийн шууд болон шууд бус санхүүжилт (татварын хөнгөлөлт, чөлөөлөлт)-ийг баталгаажуулах зохицуулалтыг нарийвчлан тусгах</li> <li>- АТБХЭ-ийн зорилгод нийцээгүй эдийн засгийн үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрөх</li> <li>- АТБХЭ-ийн үйл ажиллагааг дэмжиж гадаадаас олон улсын туслалцаа хэлбэрээр ирж байгаа бараа бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх заалтыг Гаалийн тухай хуулинд нэмэлт болгож оруулах</li> </ul>	
<p>VI. Сангийн зохицуулалт дутмаг</p>	<p>“ГУРАВДУГААР БҮЛЭГ. САНГИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДАЛ”</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сангийн удирдлага, бүтэц зохион байгуулалт, хяналт, тайлагналт зэрэг нийтлэг болон онцлог зохицуулалтыг тусгах</li> </ul>	

	<ul style="list-style-type: none"> <li>- Хувийн сангуудын нарийвчилсан зохицуулалтыг нэмэж оруулах</li> </ul>	
<p>VI. Нийтэд тустай үйл ажиллагааны зохицуулалт тодорхой бус байна</p>	<p>ТАВДУГААР БҮЛЭГ. НИЙТЭД ТУСТАЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА</p> <ul style="list-style-type: none"> <li>- Нийтэд тустай үйл ажиллагааг тодорхойлох шалгуурыг оновчтой тогтоох</li> <li>- Нийтэд тустай үйл ажиллагааны тайлагналт, хяналт үнэлгээний зохицуулалтыг нарийвчилан тодорхойлох</li> <li>- Хуулийн төслийн 45.3-р заалтыг хасах</li> </ul>	<p>Нийтэд тустай үйл ажиллагааг дэмжихийн тулд эрэмблэх шаардлагагүй. Учир нь иргэний нийгмийн байгууллагууд нийгэмд тулгамдсан асуудлаар ажилладаг. Олон тулгамдсан асуудлаас эрэмблэх нь зохимжгүй.</p>
<p>VII. Иргэний нийгмийн хөгжлийг дэмжих зөвлөлийн зохицуулалт эрсдэл бүхий байна</p>	<p>ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ИРГЭНИЙ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗӨВЛӨЛ (ИНХДЗ)</p> <ul style="list-style-type: none"> <li>- ИНХДЗ-тэй холбогдох зохицуулалтыг дахин боловсруулах. Ингэхдээ зөвлөл дэх төрийн оролцоог бууруулах, арилгах, төрөөс хараат бус байх нарийвчилсан зохицуулалт оруулах</li> <li>- ИНХДЗ хэрэв байх бол салбарын өөрөө удирдах байгууллагын зарчмаар байгуулах</li> <li>- Ажиллах журам, сонгон шалгаруулалтыг иргэний нийгэм бие даан явуулах</li> <li>- Бүх гишүүд нь ТББ-уудын төлөөлөл байх</li> <li>- Гишүүдийг хариуцлагажуулах, буцаан татах зохицуулалтыг суулгах</li> <li>- ИНХДЗ-ийн гишүүнээр сонгогдох шалгуурыг нарийвчилан тогтоох</li> <li>- ИНХДЗ-ийн гишүүний сонирхлын зөрчлийг тодорхойлох заалтыг нэмэх</li> <li>- Төрийн чиг үүргийг шилжүүлэх, гэрээлэх зохицуулалтыг тодорхой болгох</li> <li>- 48.3-т заасан Зөвлөлд нэр дэвших ашгийн төлөө бус байгууллагуудын төлөөллийг зөвхөн 5 чиглэлд үйл ажиллагаа явуулдаг байхаар</li> </ul>	<p>-</p>



	<p>хязгаарласныг нэмэгдүүлэх буюу салбар, чиглэл бүрийн ашгийн төлөө бус байгууллагууд Зөвлөлд нэр дэвших эрхийг нээлттэй байлгаж “... АТБХЭ өөр хоорондоо зөвшилцөн боловсруулсан журмаар ИНХДЗ-ийн гишүүнд нэр дэвшүүлэх төлөөллийг нээлттэй, ил тод сонгоно.” гэх.</p>	
<p>IX. Санхүүгийн хариуцлагын зохицуулалт нь дарамт үүсгэж байна</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Хуулийн төслийн 34.7-д “Нийтийн сан нь жилийн санхүүгийн тайландаа аудит хийлгэнэ. Аудит хийлгэх зардлыг тухайн сан хариуцна” гэдгийг хасаж, түүний оронд үйл ажиллагааны тайлан, санхүүгийн тайланг ил тод, нээлттэй болгох.</li> <li>- Хуулийн төслийн 45.6 заалтыг хасах</li> </ul>	<p>- Энэ хоёр заалтыг өнөөгийн ТББ-д хэрэгжүүлэх боломжгүй, аудитын зардлын санхүүжилт гаргах боломжтой ТББ цөөн. Үүний оронд орлогын эх үүсвэр, санхүүжүүлэгч бүрээр хэмжээг ил тод жагсаахыг шаардах нь илүү хэрэгжих боломжтой, мөн ач холбогдолтой.</p>
<p>X. Иргэний нийгэм дэх төрийн оролцоо нэмэгдэж, ТББ-ын хараат бус байдалд эрсдэл учруулж байна</p>	<ul style="list-style-type: none"> <li>- АТБХЭ-ийн хараат бус байдлыг хамгаалах зохицуулалтыг маш тодорхой тогтоох</li> <li>- Иргэний нийгмийн бие даасан, хараат бус байдлыг хангах, ардчиллын үнэт зүйл, хүний эрхийг баталгаажуулах</li> </ul>	<p>- Одоогийн мөрдөгдөж буй хуулийг дахин шинэчлэхдээ эвлэлдэн нэгдэх эрх болон иргэний нийгмийн хараат бус байдлыг хангах хэрэгтэй.</p>
<p>XI. Тодорхой бус нэмэлт асуудал олон байна</p>	<ul style="list-style-type: none"> <li>- “7.2.Ашгийн төлөө хуулийн этгээд нь эдийн засгийн холбоо болон хувийн сангаас бусад ашгийн төлөө бус хуулийн этгээдийг үүсгэн байгуулахыг хориглоно.” заалтыг ойлгомжтойгоор найруулах</li> <li>- “11.2.2.ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөлөх эрхгүй этгээдээс ашгийн төлөө бус хуулийн этгээдийн ашиг сонирхолын төлөө үйл ажиллагаа явуулсан, эсхүл бусдаар үйлдүүлсэн, эсхүл хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүйг тухайн хуулийн этгээдийн удирдлага мэдсэн боловч таслан зогсоох арга хэмжээ аваагүй бол.”</li> </ul>	<p>Хуулийн төсөлд тусгагдсан олон асуудлыг бусад салбар эрх зүйн зохицуулалт, хууль, эрх зүйн актаар зохицуулах, төрийн холбогдох байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хяналтын тогтолцоог нэмэгдүүлэх замаар хэрэгжүүлэх боломжтой.</p>

	<p>заалтыг ойлгомжтойгоор найруулах</p> <ul style="list-style-type: none"> <li>- Сайн дурын үйл ажиллагааг дэмжих тухай хууль, хандивлагч донор байгууллага, хандив өгөх авахтай холбоотой хуулийн зохицуулалт дутуу орсныг нэмэх.</li> </ul>	
<p>XII. Иргэний нийгмийн үзэл баримтлал батлагдаагүй, ашгийн төлөө бус салбарыг дэмжих төрийн бодлого байхгүй</p>	<ul style="list-style-type: none"> <li>- "Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал" буюу төрөөс иргэний нийгмийн салбарыг дэмжих бодлогын баримт бичгийг судалгаа, бодит онцлогт тулгуурлан боловсруулж, АТБХЭтХ-ийн төсөлтэй хамт өргөн барих.</li> <li>- Хуулийн төслийг олон нийтээр хэлэлцүүлэх, иргэд олон нийт, ТББ-уудыг мэдээллээр хангах замаар хуулийн төсөл дээр зөвшилцлийг бий болгох. Ингэхдээ хөдөө орон нутаг хийгээд бүхий л салбарт үйл ажиллагаа явуулж буй ТББ-уудын саналыг авч оролцуулах.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Иргэний нийгмийн үндсэн зарчим, үнэт зүйл, хөгжлийн үндсэн чиглэл зэргийг тодорхойлсон баримт бичгийг боловсруулж батлах замаар үндэсний зөвшилцөл, ойлголтыг нэмэгдүүлэх нь чухал. ИНБ-уудын санаачлагаар 2009-2012 онуудад олон удаагийн цуврал уулзалт, зөвлөгөөн, нөлөөллийн үр дүнд тухайн үеийн Засгийн газрын дэмжлэгээр хамтарсан Ажлын хэсэг байгуулагдаж, "Иргэний нийгмийн хөгжлийн үзэл баримтлал"-ын төсөл боловсруулагдсан.</li> <li>- Иргэний нийгмийн харилцааг зохицуулдаг олон хууль, эрх зүйн баримт бичгүүд байгаа ч тэдгээрийг уялдуулах, нэгтгэн зангидах үзэл баримтлал байхгүй тул хуулийн зөрчил, хийдэл гарах нөхцлийг үүсгэж байна.</li> <li>- Тухайлбал Иргэний хууль, Татварын тухай хууль, Улсын бүртгэлийн тухай хууль гэх зэрэг хуулиудыг боловсруулан батлахдаа иргэний нийгмийн байгууллага, ТББ-ын эрх ашгийн үүднээс нэгдсэн бодлого</li> </ul>

		<p>уялдуулж боловсруулсан байдал дутмаг байдгаас ТББ-ын төрөл ангилал хоорондоо зөрүүтэй байх гэх мэт зөрчлүүд гарч байна.</p> <ul style="list-style-type: none"> <li>- Иргэд, олон нийт төдийгүй ТББ-ууд болон бусад оролцогч талууд АТБХЭтХ-ийн төсөлтэй танилцаагүй, түүний талаар мэдээлэл ойлголтгүй байна. Талууд мэдээлэл, ойлголтгүй байгаа нь нийгмийн хэрэгцээнд тохирсон хуулийн төсөл боловсруулах, батлах, хуулийн цаашдын хэрэгжилтийг хангахад саад учруулна.</li> </ul>
--	--	---

Саналуудыг эмхэтгэн нэгтгэсэн: Ардчиллын боловсрол төв (ДЕМО)

## Хавсралт 1.

Бүртгэлийн байгууллагын хүнд суртал болон эвлэлдэн нэгдсэн иргэдийг бүртгэхгүй,  
хүний эрхийг зөрчсөн бодит ГУРВАН КЕЙС

## Кейс 1: LGBT төвийн бүртгэл

*Бүртгэлийн газар лесби, гей, трансжендер төв гээд бүртгүүлэх гэтэл нэрээ монголоор орчуул гэсэн шаардлага тавьсан. Тэгээд бид холбогдох албан тушаалтантай уулзсан. Бидэнд лобби нөлөөллийн ажил хийж болохгүй, нэрийг зөвшөөрөхгүй гэсэн, тэгээд монголын уламжлал зан заншилтай нийцэхгүй гэсэн утгатай бичиг бидэнд өгсөн. Бүртгэлийн газар бидний ажлыг эротик, порног сурталчилах гэж байна гэж ойлгосон. Лесби, гей, трансжендер төвийг байгуулах нь чухал, энэ нэрээрээ байвал холбогдох хүмүүс нь хандахад саадгүй болно. Манай байгууллагыг олон нийтийн ёс суртахуунд нийцэхгүй гэсэн тул бид өмгөөлөгч авсан. Бид олон улсын байгууллагад хандаж асуухад тэр хэвээр нь нэрлэ гэсэн. Бүртгүүлэх гэж 10 гаруй удаа очиж буцаж байж нэг бүртгүүлсэн.*

## Кейс 2: МОНФЕМНЕТ-ийн бүртгэл

*Байгууллагынхаа нэрийг Монголын эмэгтэйчүүдийн ТББ-ын үндэсний сүлжээ гэж нэрлээд бүртгүүлэхээр 4-5 удаа очсон. Ингэж олон дахин очсоны шалтгаан нь МОНФЕМНЕТ гэдгийг товчилсон үгээр байна, гадаад үг орсон байна, Сүлжээ гэдэг нь эмийн болон гоо сайхны сүлжээтэй адил байна гэх зэргээр буцааж байсан. Тэгээд бүртгэлийн байгууллага бидэнд “Хатан ижий” гэдэг нэр санал болгосон. Олон явсны эцэст бид МОНФЕМНЕТ нэрээр бүртгүүлсэн.*

## Кейс 3: Монголын комиксын холбоо

*Монголын комиксын холбоо гэдэг нэр авах гэсэнд бүртгэлийн байгууллагаас “Хөдөлгөөнт зургийн холбоо” гэдэг нэр өг гэсэн. Зарим оноосон нэрийг гадаад үгээр байх нь даяаршлын үеийн чухал асуудал болдог.*

Эх сурвалж: Ардчиллын боловсрол төв (ДЕМО)  
2019